

Агуулга

1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга
 - 1.1 Ерөнхий мэдээлэл
 - 1.2 Уурхайн хүчин чадал
 - 1.3 Тухайн оны уулийн ажил гүйцэтгэлийн мэдээ
 - 1.4 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн зорилго
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
10. Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Дүгнэлт

Хавсралт материалууд:

- ✓ Улсын бүртгэлийн гэрчилгээ
- ✓ Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл
- ✓ Сум орон нутагтай хийгдсэн нийгмийн хариуцлагийн гэрээ, төлбөр
- ✓ Тухайн жилийн усны ашиглалтын гэрээ, төлбөр
- ✓ Тухайн жилийн газар эзэмшлийн гэрээ, төлбөр
- ✓ Тухайн жилийн хог хаягдлын гэрээ, төлбөр
- ✓ Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг харуулсан гэрэл зураг
- ✓ Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн хээрийн хэмжилт, авсан дээжүүдийн лабораторийн шинжилгээний үр дүн эх хувиар
- ✓ БОХ-3 маягт. Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн жилийн мэдээ
- ✓ БОМТ-ний биелэлтийн тайлан хүлээн авах хяналтын хуудас

1.Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга

1.1. Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр “Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордыг ашиглах төсөл”

Төслийн зорилго, ач холбогдол

Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх замаар төсөл хэрэгжүүлэх 5 жилийн хугацаанд 394.86 мян.м3 элс угаан баяжуулж, 470.79 кг алт борлуулах ба тодорхой тооны хүмүүсийг ажлын байраар ханган, өөрийн компанийн болон улс, орон нутгийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, Ашигт малтмалын тухай хуулийн 35.5-д заасны дагуу ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглахад чиглэгдэнэ.

Төсөл хэрэгжүүлэгч

“Ай Би Би Ай” ХХК, Захирал: Ч.Оюунгэрэл


Улсын бүртгэлийн дугаар: 9011453143

Регистрийн дугаар: 5809797

Утас: 99113446

Төслийн байршил

Галтын амны MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай нь Монгол Улсын засаг захиргааны нэгжийн хувьд тэрээр Төв аймгийн Заамар сумын нутагт оршино. Тус орд нь Улаанбаатар хотоос 195 км, Заамар сумаас 35 км-г оршино.



Зураг №1 Ордын байршил

Тусгай зөвшөөрөл нь байр зүйн хувьд М-48-137 хавтгайд нийт 3506,94 га талбайг хамрах ба газар зүйн солбилцлыг хүснэгт № 1-д үзүүлэв.

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн солбицол

Булангийн цэгийн дугаар		Координат	
MV-020602 3506,94 га	1	104° 22' 59,42''	48° 10' 49,82''
	2	104° 23' 27,69''	48° 10' 28,59''
	3	104° 25' 40,4''	48° 10' 38,49''

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын
2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

4	104 ⁰ 25' 34,32''	48 ⁰ 08' 5,31''
5	104 ⁰ 18' 47,94''	48 ⁰ 08' 2,81''
6	104 ⁰ 18' 47,94''	48 ⁰ 08' 14,35''
7	104 ⁰ 18' 42,36''	48 ⁰ 08' 14,35''
8	104 ⁰ 18' 42,36''	48 ⁰ 08' 17,79''
9	104 ⁰ 18' 33,01''	48 ⁰ 08' 17,79''
10	104 ⁰ 18' 33,01''	48 ⁰ 08' 20,26''
11	104 ⁰ 18' 25,15''	48 ⁰ 08' 20,26''
12	104 ⁰ 18' 25,15''	48 ⁰ 08' 48,82''
13	104 ⁰ 18' 18,69''	48 ⁰ 08' 48,82''
14	104 ⁰ 18' 18,69''	48 ⁰ 09' 03,15''
15	104 ⁰ 18' 14,07''	48 ⁰ 09' 03,15''
16	104 ⁰ 18' 14,07''	48 ⁰ 09' 20,5''
17	104 ⁰ 18' 19,91''	48 ⁰ 09' 20,5''
18	104 ⁰ 18' 19,91''	48 ⁰ 09' 21,76''
19	104 ⁰ 18' 22,95''	48 ⁰ 09' 21,76''
20	104 ⁰ 18' 22,95''	48 ⁰ 09' 23,63''
21	104 ⁰ 18' 25,33''	48 ⁰ 09' 23,63''
22	104 ⁰ 18' 25,33''	48 ⁰ 09' 25,88''
23	104 ⁰ 18' 27,74''	48 ⁰ 09' 25,88''
24	104 ⁰ 18' 27,74''	48 ⁰ 09' 49,82''
25	104 ⁰ 18' 34,91''	48 ⁰ 09' 49,82''
26	104 ⁰ 18' 34,91''	48 ⁰ 09' 21,82''
27	104 ⁰ 20' 00,92''	48 ⁰ 09' 21,82''
28	104 ⁰ 20' 00,92''	48 ⁰ 09' 49,82''
29	104 ⁰ 20' 40,91''	48 ⁰ 09' 49,82''
30	104 ⁰ 20' 40,91''	48 ⁰ 10' 49,82''

1.2. Уурхайн хүчин чадал

Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордын уурхайн 2022 онд 27.7 га талбай олборлолтод өртсөн бөгөөд:

1. Нийт уулын цул	6927,8 мян.м ³
2. Шимт хөрс	55,4 мян.м ³
3. Хучаас хөрсний хэмжээ	4461,8 мян.м ³
4. Нуурын ажил	2410,6 мян.м ³
5. Элсний хэмжээ	102.045 мян.м ³
6. Алтны нөөц / химийн цэврээр /	171,6 кг байсан.

Уурхайн ашиглалтын систем

Уг орд нь ашиглалтын гүн ойролцоо, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигладаг. Иймд бульдозероор эхэлж шимт хөрсийг ил уурхайн хил хүрээний гадна талд түрж шимт хөрсний овоолго үүсгэсний дараа түүний доорхи хөрс болон элсэн давхаргыг экскаватор-автосамосвалын хослолоор зөөж тээвэрлэдэг.

Үндсэн хөрсийг эхний ээлжинд гадаад овоолгод байрлуулж, ашиглалтын хоосон орон зай үүссэн шууд дотоод овоолго хийх замаар ажиллав. Энэ нь хөрс болон шимт

хөрсний давхаргуудыг холихгүйгээр анх байсан төлөвт нь эргүүлэн оруулж нөхөн сэргээлт хийх боломжийг бүрдүүлсэн.

Алт агуулсан элсийг угаах төхөөрөмж байрласан талбайд зөөвөрлөн овоолго үүсгэн, үүссэн овоолгоосоо утгуурт ачигчаар угаах төхөөрөмжийг тэжээн ажиллалаа.

Уурхайн ажилласан горим

Галтын амны алтны шороон ордын уурхай нь улирлын чанартай ажиллаж 3-р сарын 1-нээс 12 сарын 1 хүртэл ажилласан.

➤ Усан хангамжын эх үүсвэр, усны хэрэглээ

Унд ахуй:

Уурхайд байнгын 160 хүн ажилласан тул хоногт $150\text{л}/\text{хоног}/\text{хүн} * 160 \text{ хүн} = 24\text{м}^3$, сард $24\text{м}^3 * 30 = 720\text{м}^3$, жилд $275 \text{ хон} * 24\text{м}^3 = 6600 \text{ м}^3$ ус хэрэглэсэн.

Унд, ахуйн усны хэрэглээ

Ашиглалтын жил	Ажилчдын тоо	Хоногт, м ³	Сард, м ³	Жилд, м ³
2022	160	24	720	6600

Унд ахуйн хэрэгцээнд 2022 онд 6600 м^3 буюу $0.03 \text{ л}/\text{сек}$ ус хэрэглэсэн.

Баяжуулалт: Галтын амны алтны шороон ордын баяжуулалтанд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 2-р хавсралтын дагуу 1 м^3 элс угаан баяжуулахад 4.0 м^3 ус орохоор тооцоолов. 2022 онд 102.045 мян.м^3 элс угаан баяжуулсан.

Баяжуулалтанд $102045 \text{ м}^3 * 4.0\text{м}^3 = 408180 \text{ м}^3$ ус ашигласан. Үүнээс 81636 м^3 цэвэр усыг нөхөн сэлбэлтээр ашиглав. Учир нь ижил төстэй уурхайнуудад алтны шороон ордын баяжуулах үйлдвэрийн эргэлтээр ашиглах усны хэмжээг 80% гэж тооцоолдог байна. Иймд тус төслийн ТЭЗҮ-д тооцоолсны дагуу эргэлтээр ашиглах усны хэмжээг 80% гэж тооцлоо.

Тоос дарах: Дотоод тээвэрлэлт, хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт дарахад шаардлагатай усны хэрэглээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 13-р хавсралтын дагуу 1 м^2 талбайн тоосжилт дарахад 2 л ус зарцуулахаар тооцоолов. Жилд 10км урт, 6м-ийн өргөнтэй зам талбай усласан ба хоногт 1 удаа, 1 жилд 45 хоногийн хугацаанд усалгаа хийв. $45\text{хоног} * 10000\text{м} * 6\text{м} * 2\text{л} = 5400\text{м}^3$ ус хэрэглэсэн.

Биологийн нөхөн сэргээлтийн ус хэрэглээ:

Нөхөн сэргээлтэнд зарцуулагдах усыг БОНХАЖ-ын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны А/301 дугаар тушаалын 11-р хавсралтын дагуу олон наст ургамлаар нөхөн сэргээсэн талбайг $4 \text{ л}/\text{м}^2$ нормоор услахаар тооцсон боловч тайлант 2022 онд бороо хур ихтэй байсан тул биологийн нөхөн сэргээлтэд ус ашиглаагүй.

2022 оны уурхайн нийт ус хэрэглээ

Баяжуулалт, м ³	Унд ахуй, м ³	Тоос дарах, м ³	Биологийн нөхөн сэргээлт, м ³	Нийт ус хэрэглээ, м ³
81636	6600	5400	0	93636

2022 онд уурхайд нийтдээ 93636 м³ ус хэрэглэсэн ба усны хэрэгцээг гадаргын уснаас хангаж ажиллалаа.

➤ **Цахилгаан хангамжийн үүсвэр**

Галтын амны алтны шороон орд нь дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт орших бөгөөд төвийн эрчим хүчний эх үүсвэрээс өөрийн хөрөнгөөр салаалуулан өндөр хүчдлийн шугам татан авсан тул түүнийгээ ашигласан.

1.3. Тухайн оны уулын ажил гүйцэтгэлийн мэдээ

XV-019220 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий "Доргонот, Улаан ухаа" талбайд “Алтандорнод Монгол” ХХК 2005-2006 онуудад явуулсан эрлийн ажлын үр дүнгээр алтны шороон хуримтлал бүхий хэд хэдэн хэсэг ялгаснаас “Ай Би Би Ай” ХХК нь 2015-2016 онуудад галтын амны дээд хэсгийн алтны шороон орд, туул дэнжийн алтны шороон хуримтлал гэсэн хоёр хэсэгт геологи хайгуулын ажлыг явуулж, өрөмдлөгийн торыг нягтруулан судалж улмаар ордын нөөцийг бодитой В зэргээр, илрүүлэгдсэн баялаг Р1 зэрэгт хамааруулан тооцоолсон.

Төслийг хэрэгжүүлэгч "Ай Би Би Ай" ХХК нь Төв аймгийн Замаар сумын нутагт орших "Галтын ам"-ны алтны шороон ордыг Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд эдийн засгийн хувьд үр ашигтай, байгаль орчинд ээлтэйгээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулж улмаар улс, орон нутгийн эдийн засгийн өсөлтөнд бодитой хувь нэмэр оруулах, үйлдвэрлэлийн хаягдал багатай шинэ техник технологи, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шинэ дүрэм журам нэвтрүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийг бүрэн хийх, орон нутагт хүлээлгэн өгөх зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаа явагдаж байгаа нутаг юм.

2018 онд нарийвчилсан хайгуулын ажил явуулж ЭБМЗ-өөр нөөц батлуулан 2020 онд ТЭЗҮ батлуулсан. Уг ТЭЗҮ-ээр 5 жил ашиглахаар төлөвлөгдсөн ба 2022 онд уг ордын Галтын амны дээд хэсгийн гүний В-2, В-5 блок Галтын амны дээд хэсгийн бага гүний В1-В3, С-1, С-2 блокыг бүрэн олборлосон, мөн баяжуулахын дэргэдэх нуурын хэсэгт хөрс хуулалтын ажил хийсэн болно.

Уурхайн олборлолтонд нийт 27.7 га талбай, нуурын хэсэгт гадаад овоолго тооцсоноор нийт 38,9 га талбай гадаад овоолгод, 3 га дотоод овоолгод, 0,5 га талбай шимт хөрсний овоолгод, 2,2 га талбайд уурхайн зам хийхэд, 0,5 га талбай элсний, 2,0 га талбай нуур цөөрөм хийхэд өртсөн.

Уурхайн олборлолтын талбайгаас 4461,8 мян.м³ хөрс хуулан, дунджаар 1,681/м³ агуулгатай 102.045 мян.м³ элс олборлон баяжуулж, химийн цэврээр 171,6 кг алт олборлосон.

Ил уурхайн уулын ажлыг тээвэрлэлтийн системээр экскаватор, автосамосвалын хослолын ашиглалтын системээр гүйцэтгэсэн.

Галтын амны дээд хэсгийн алтны шороон орд нь 2022 оны 3-11 сар дуустал хоногт 2 ээлжээр ажилласан бөгөөд ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байсан.

2022 онд Галтын амны шороон ордын гүний хэсэгт ашиглалт явуулж байгаатай холбоотойгоор техникийн нөхөн сэргээлтийн ажил В-3 блокын хүрээнд 3 га талбайд хийгдсэн бол биологийн нөхөн сэргээлтийн ажилд кемпийн хашаанд мод тарьсан болно.

1.4 Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн зорилго

“Ай Би Би Ай” ХХК-ийн Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах явцад байгаль орчинд учруулж болзошгүй гол сөрөг нөлөөллийг тодорхойлох, сөрөг нөлөөллийг багасгах болон арилгах үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлыг төлөвлөсөны дагуу, сөрөг нөлөөллийг бууруулах талаар зөвлөж боловсруулахыг зорьсон болно.

Ил уурхайн олборлолтын явцад байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Ил уурхайн олборлолтын явцад анхаарах гол зүйл бол ил уурхайн олборлолтын явцад үйл ажиллагааг технологийн дагуу гүйцэтгэх, ил уурхайн ойр орчмын хөрс, ургамлан бүрхэвчийг хамгаалах явдал юм. Иймээс байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуух ажуудыг хангаж ажилласан болно.

2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг хэрэгжүүллээ.

Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлуудаас төлөөлүүлэн дурьдваас.

Төлөвлөлт	Хэрэгжилт	Нийт зардал, сая.төг
Унд ахуйн болон үйлдвэрлэлд ашиглагдаж буй ус, үйлдвэрлэлээс гарсан уснаас тус шинжилгээ авахуулж, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Ундны уснаас 1 удаа, технологийн уснаас 1 удаа дээж авч шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүн хэвийн гарсан бөгөөд шинжилгээг хавсаргав.	0,3
Баяжуулах хэсэгт ашиглагдах угаах төхөөрөмжийн ус зарцуулалтыг хянан аль болох бага хэмжээнд байлгаж, элсийг сайтар ангилан ялгах	Элс олборлолтын үед элсний дээжлэлтийн ажлыг байнга хийж ангилан ялгаж байв. Элсэн дэх агуулгагүй үеийн зузааныг 0,4м-ээс хэтрүүлэлгүй ангилсан.	1,3

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын
2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Баяжуулах хэсгийн нуурын нэвчилт, ууршилтыг бага хэмжээнд байлгах	Нуурыг лаг шавраар доторлох, бага талбайд нуур байгуулах ажлыг хийж гүйцэтгэв.	0,8
Шилийн сар, шонхор зэрэг махчин шувуудын үүр оромж, ангуучлах нутаг, тэдгээрийн идэш тэжээл бологч амьтдын элбэгшил, байршил нутаг зэргийг харгалзан хиймэл үүр барьж өгөх	2 ширхэг шувууны үүр хийж ууланд байрлуулсан.	0,2
Олон салаа зам гаргахгүй байх, гаргасан төв замаа салхитай үед услаж ургамал, амьтанд нөлөөлөх нөлөөллийг бууруулах	Уурхай, баяжуулах хэсэг, ажилчдын хотхонг холбосон уурхайн төв замыг барьж шаардлагатай үед усалж байв.	1,3
Ухашуудыг тойруулан хашиж амьтан орохоос сэргийлэх	Уурхайн хүрээг тойруулан эмжих байдлаар зурвас хөрсний овоолго байршуулсан.	0,5
Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	Үйл ажиллагаа эхлэх үед бүх ажилчдын дунд сургалт явуулж ухуулан сурталчлах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардал
Салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйл ажиллагааг хязгаарлах	Салхи, хуурайшилт ихтэй өдрүүдэд зам усалгааг байнга хийж байсан ба	0
Дотоод замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд 2-4 л/м ² нормоор услаж байх,	салхи ихтэй үе үйл ажиллагааны туршид бага байсан.	1,3
Машин техникийн яндангаас ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах	Манай уурхай сүүлийн үеийн дэвшилтэт техник, машин механизмыг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ба нийт машин механизмууд 2017 оноос хойш үйлдвэрлэгдсэн. Иймээс хорт утааны ялгаралт стандартын түвшинд байх үндэслэлийг бий болгож байгаа юм.	0
Олборлолт явуулах, хөрс хуулах, овоолго хийх, баяжуулах үйлдвэр байгуулах, эргэлтийн усан сан барих зэргээр газар эвдэх бусад үйл	Тайлант 2022 онд нийт 6,9 мян.м ³ шимт хөрс хуулсан.	Үйл ажиллагааны зардалд оруулж тооцов.

ажиллагааг эхлүүлэхийн өмнө өнгөн хөрсийг 0.3-0.5м зузаантайгаар хуулж овоолго байгуулан стандартын дагуу хадгалах		
ШТМ-ын хадгалалт, хамгаалалтыг сайн байлгаж хөрсийг бохирдуулахгүй байх	ШТС болон засварын газар орчмын шимт хөрсийг хуулж 0,5м зузаантай хайрган хучилт хийсэн бөгөөд тохиолдлоор асгаралт үүссэн нөхцөл тэр даруйд нь хуулж аван оронд нь цэвэр хайрган хучилтыг хийдэг.	3,2
Нийт зардал, сая.төг		8,9

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

Галтын амны шороон ордын нөхөн сэргээлтийг “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008”, “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт”, “Эвдэрсэн газрыг ургамалжуулах Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын шаардлагад нийцүүлэн БОНХАЖ-ын сайдын 2015 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-138 дугаар тушаалаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэнэ.

2022 онд 27,7 га талбай олборлолтод өртсөн. Уулын ажил дууссаны дараа олборлолтонд өртсөн талбайг дотоод овоолгоор түрж тэгшлэн хэлбэршүүлэх ба нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, түүнд зарцуулагдах зардал, биологийн нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ болон зардлыг доорх хүснэгтэнд үзүүлэв.

2022 оны нөхөн сэргээлтийн ажил

Үзүүлэлт	Төлөвлөлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
Техникийн нөхөн сэргээлт, га	2,0	3,0	100	2020 онд батлагдсан шинэ нөөцийн ашиглалтын хил тайлант онд нөхөн сэргээхээр төлөвлөсөн талбайтай давхцаж байгаа тул нөхөн сэргээх ажлын зарим хэсгийг хийгээгүй болно.

Биологийн нөхөн сэргээлт, га	0	Кемпийн хашаанд нийт 300 ширхэг мод тарьсан болно.	0	Тэрбум мод санаачлагийн хүрээнд орчны бүсээ ойжуулан мод тарьж биологийн нөхөн сэргээлтээ гүйцэтгэсэн.
------------------------------	---	--	---	--

Уурхайлалт эхлэхийн өмнө турхайн жилд нөлөөлөлд /олборлолтонд өртөх хөрсний овоолгод дарагдах, тунаах нуурын зориулалтаар ухах/ өртөх талбайн шимт хөрсийг хуулах, шимт хөрсний овоолго үүсгэх

- Хөрсний гадаад болон дотоод овоолго үүсгэх
- Дотоод, гадаад овоолгоор ухагдсан сул орон зайг нөхөн дүүргэх
- Нөхөн дүүргэсэн болон гадаад овоолгын талбайг тэгшлэх, хэлбэршүүлэх, нягтаршуулах
- Эргэлтийн усан санг хуурайшуулах, хурдас чулуулгаар дүүргэх, тэгшилж хэлбэршүүлэх
- Бусад нөлөөлөлд өртсөн талбайг түрж тэгшлэх
- Тэгшлэлт, техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг шимт хөрсөөр хучих
- Шимт хөрсөөр хучсан талбайд биологийн нөхөн сэргээлт хийх
- Уурхай хаагдсаны дараа хяналт шинжилгээ, хянан магадлагаа хийх зэрэг болно.

Шимт хөрсийг хадгалахдаа уурхайн ашиглах хэсгийн гадна талд шимт хөрсний овоолго үүсгэн “MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хадгална. Олборлолтонд өртөх талбайн шимт хөрсийг жил бүрт нь хуулах ба хуулсан шимт хөрсөө тухайн жилдээ эсвэл дараагийн жилд нөхөн сэргээлтэнд ашиглана.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлын хувьд ерөнхийлөгчийн зарилагийн хүрээнд хийгдэж буй тэрбум мод тарих ажлын хүрээнд 300 ширхэг мод уурхайн кэмп орчны орчний бүст тарьж биологийн нөхөн сэргээлт хийгдсэн болно.

Уурхайн техникийн нөхөн сэргээлтийн дотоод овоолгоор дүүргэлт хийх ажлын зардлыг уурхайн үйл ажиллагааны зардал шингээн оруулсан тул тайлант онд нөхөн сэргээлтийн ажлын зардал тусгайлан гараагүй.



Зураг №3 Хөрс хуулалтын ажил Дотоод овоолгоор дүүргэлт хийж байна.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг (БОМТ) БОНХСайдын 2014 оны 1 сарын 24 ны өдрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” – ын дагуу хийж боловсруулж, БОХ – 3 маягт болон нөхөн сэргээлтийн хийсэн талбайг хүлээлцэх актыг тайланд хавсаргалаа.

**4. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний
төлөвлөгөөний биелэлт**

Төв аймгийн БОАЖГ-аас Заамар сумын Хайлааст багийн нутагт уулын ажилд өртөж эзэнгүй орхигдсон 4,92 га талбайд дүйцүүлэн хамгааллын ажил хийлгэхээр координат зааж өгсөн. Энэ ажлын хүрээнд 2022 оны 11-р сарын 1-ны өдрөөс дүйцүүлэн хамгаалах ажлыг D-8 бульдозер-1ш, 160-k автогредер-1ш зэрэг техникүүдээр 2022 оны 11 сарын 7-оос 11 сарын 24 хүртэл 17 хоногийн хугацаанд 4,92 га газрыг дүүргэлт хийн тэгшитгэн нөхөн сэргээж гүйцэтгэлээ.

Уг ажилд “Ай Би Би Ай” ХХК-ны зүгээс 3 оператор 1 маркшедрийн инженерийн бүрэлдэхүүнтэй ажилласан бөгөөд дүйцүүлэн хамгаалахын ажлын хүрээнд хийгдэж буй нөхөн сэргээлтийн зардалд нийт 63,6 төгрөг зарцуулсан болно.

Дүйцүүлэн хамгаалах ажлын зардлын задаргаа:

№	Техникийн нэрс	Түлш /л/	Зардал, сая.төг
1	D-8 бульдозер	7200	25,2
2	160K-Автогридер	2600	9,1
3	Ажилтны цалин	-	8,5
4	Траллер	Баруунхараагаас зөөвөрлөсөн	12,0
5	Урсгал зардал	Хоол унаа, Гослох материал	8,8
Нийт зардал			63,6

Фото зураг №4: Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдэж буй нөхөн сэргээлтийн фото болон ажлын зурагнууд.




Нөхөн сэргээхийн өмнөх зураг



Нөхөн сэргээсний дараах зураг

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

MV-020602 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд малчдын өвөлжөө, хаваржаа гэх мэт суурьшилд олгогдсон талбай байхгүй тул энэ арга хэмжээг төлөвлөөгүй. Гэхдээ тайлант 2022 онд Хайлааст багийн малчин өрхүүдэд нийт 49 сая төгрөгийн малын тэжээл, өвс, ногоон тэжээл хандив бологон өгсөн.

6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд 2018 онд археологи, палеонтологийн судалгааны ажлыг явуулж авран хамгаалах ажил хийгдсэн тул тайлант 2022 онд түүх соёлын өвийг хамгаалах талаар нийт ажиллагсадад сургалт зохион байгуулсан.

7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд олборлосон элсийг уурхайн талбайд скрубээр баяжуулна. Өөрөөр хэлбэл, ажилчид, инженер, техникийн ажилтнууд ажлын хариуцлага алдах, ялангуяа үйл ажиллагааны явцад технологийн горим зөрчсөнөөс элдэв осол гарч, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагаа саатах, ажиллагсадын эрүүл мэнд хохирох, хөдөлмөрийн чадвараа алдах, тахир дутуу болох, хүний амь нас эрсдэх зэрэг осол аваар гарч болзошгүй тул аюулгүй ажиллагааг анхаарч ажиллах шаардлагатай.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг
Түлшний агуулах, автомашин, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Бүх ажилчдыг гал түймэр унтраах компанийн дотоод сургалтад хамруулсан	1,5
	Гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан.	0.5
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулсан.	0.1
Ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө өдөр бүр аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулдаг.	-
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн мэргэжилтнүүдтэй хамтран нийт ажилтан ажиллагсадад аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан.	0,2
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	- Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах, - Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулах	-
	Жолооч бүрийг даатгалд хамруулах	0.5
	Машины кабин бүрт эмийн сан, галын хор байрлуулах зэрэг ажлуудыг хийсэн.	

Нийт зардал, мян.төг	2,8
----------------------	-----

Гал түмэр:

Уг нутаг дэвсгэр нь гал түймэрийн аюул осол ихтэй бүс нутагт хамаарах бөгөд хавар, намрын улиралд салхи, шуурга ихтэй байдаг учир ил задгай газарт гал гарахаас болгоомжлох нь чухал.

Уурхайн жил бүрийн уулын ажлын төлөвлөгөө болон аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэсжээг тусгаж гал унтраах багаж хэрэгсэлээр хангаж ажилладаг.

2022 онд гал түймэрийн болзошгүй аюулын талаар компаний зүгээс шаардлагатай арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч ажилласан.



Фото зураг №5: Галын сургалт явуулж байгаа нь

Хөрс:

Хөрсийг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахгүй байх зэрэгт анхаарч ажилласан. Шатах тослох материалын хадгалах агуулах, засвар үйлчилгээний талбай, хаягдал тос, тосон бүтээгдэхүүний агуулах зэргийг үер ус, галын аюулд өртөхөөргүй газарт сонгон байгуулсан.

Шатах тослох материал, хаягдал тос-тосон бүтээгдэхүүний агуулах зэрэгт санамсаргүй тохиолдлоор асгарахаас урьдчилан сэргийлж сануулга, самбар, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж, тусгайлан сургалт явуулсан болно. Мөн сэрдэлийн үед хэрэглэх эд материал, элс хайрга, галын аюулгүйн булан байгуулж, онцгой бүсийн тусгай тэмдэг тэмдэглэгээг байрлуулж ажиллаа. Уурхайн бүсэд хөрсний дээж авхуулж химийн шинжилгээ хийлгэсэн.

Хөрс чулуулаг болон ургамлын био давхаргын бүрхэвчийг гэмтээж хордуулахгүй байх ухамсарт суралцуулан ажиллаж байна.



Фото зураг №6: ШТМатериалыг битүүмжлэлтэй саванд хадгалж байгаа нь

Олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудыг хийж, замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавьж тэмдэгжүүлсэн. Сургалт, сурталчилгааг тогтмол явуулж ажиллаа.



Фото зураг №7: Замын тэмдэг тэмдэглэгээ



Фото зураг №8: Шөнийн ээлжинд ажиллахад уурхайн хананы нуралт болон зам талбайг гэрэлтүүлсэн гэрэлтүүлэг

"Галтын амны дээд хэсэг"-ны шороон ордод алт агуулсан баяжмалыг баяжуулахад усаар угаан хүндийн хүчний буюу гравитацийн аргаар баяжуулдаг учир ямар нэгэн химийн бодис ашигладаггүй эерэг онцлогтой. Иймд баяжуулах үйлдвэрт ямар нэгэн химийн бодис хэрэглээгүй болно.

8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагаа явагдаж эхлэхэд хог хаягдал гарснаар тухайн газар нутгийг бохирдуулах, мөн ажиллаж амьдарч байгаа ажилчид, нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай тул дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

Уурхайн хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, устгах, булах үйл ажиллагаа нь БОНБНҮ-нд тусгасны дагуу, мөн Заамар сумын Хайлааст багтай гэрээ байгуулж ажилласан. Гэрээг хавсаргав.

Уурхайн хог хаягдлыг дараах байдлаар ангилсан. Үүнд:

1. Ахуйн хэрэглээний хог хаягдал
2. Шингэн хог хаягдал
3. Хатуу хог хаягдал

Ахуйн хэрэглээний хог хаягдал ажилчдын байрнаас гарах хог, цайны газраас гарах хаягдал, ажлын байрны хог, тосгоноос гарах хог хаягдлууд багтана. Ахуйн хэрэглээний хог хаягдлыг тусгайлан бэлдсэн битүүмжлэл сайтай савнуудад цаас, хуванцар, бусад зэргээр ялган ангилж, цаас хуванцарыг нь шатаах, гарсан үнс нурамыг нь бусад хог хаягдалтай төвлөрсөн хогийн цэгт хаядаг.



Фото зураг №9: Хог хаях цэг болон тамхи татах цэг.

Шингэн хог хаягдалд: Уурхайн хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээ хийгдсний дараагаар сольсон тос масло, шүүр, ахуйн хэрэглээний бохирын ус гэх мэт хаягдал гарна. Техникийн засвар үйлчилгээг хийхдээ шингэнийг зориулалтын саванд тосж аван, шүүлтүүрийг хатуу хог хаягдал буюу төмрийн хаягдалд тусад нь байрлуулсан. Шингэн хаягдал буюу тос маслаг хувь хүн болон аж ахуйн нэгжид хэрэгцээгээр нь борлуулж худалдах, хүйтэн сэрүүний улирал эхлэхэд угаах төхөөрөмж болон механик цехийн зуухнуудыг халаахад ашигладаг байсан ба бусад хог хаягдлыг төвлөрсөн цэгт зохих журмын дагуу дарж булах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

Ахуйн хэрэглээний шингэн бохирын хаягдлыг цооног байгуулан түүнд зайлуулан ариутгалыг тогтмол хийж ашиглалтын хугацаа дуусахад ариутган дарж булшлах арга хэмжээг авна. Үүнээс гадна бие засах газрын битүүмжлэлийг сайн хийж, тогтмол ариутгал цэвэрлэгээ хийх арга хэмжээг авч ажилласан.

Хатуу хог хаягдалд:

Уурхайн механик цех, токарийн суурь машин, засвар үйлчилгээ хийгдсэн машин механизмаас гарах хатуу хог хаягдлууд орно. Иймд уулын тоног төхөөрөмж, засварын газар болон үйлдвэрлэлийн үүсэлтэй металл хаягдлыг тусгай талбайд хаглага хийн цуглуулж, тээвэрлэн борлуулахад бэлтгэн хураасан.

Хотод түүхий эд авах цэгүүдэд тушааж байна.

Фото зураг №10: Хаягдал төмөр, дугуй зэргийг тусад нь ялгаж Улаанбаатар



Төслийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг зайлуулахдаа дараахь дэс дарааллыг баримталж ажилласан

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь арилгах, бууруулах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин ашиглах (хэрэв шаардлагатай бол сэргээн зассаны дараа)

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан нь хог хаягдлыг дахин ялгах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг ажилчдын хотхон, засварын газар, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих ажлыг хийж гүйцэтгэсэн.	0,4
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх	-
Хог хаягдалаар хөрс, газрын доорхи ус бохирдож болзошгүй	Хог хаягдал түр хадгалах талбайг шимт хөрсийг нь хуулан хайргаар зузаан дэвсэлт хийж нэвчилт явагдахааргүй болгосон.	0,1
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх ахуйн хатуу болон шингэн хог хаягдлаар хөрс, гадаргын болон газрын доорхи ус бохирдуулах сөрөг	Хуванцар сав, шил, лааз гэх мэт хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаахаар цуглуулж байгаа.	0,25
	Дугуйн хаягдлыг байгальд шууд хаялгүй тусгай талбайд цуглуулж байгаа.	0,1
	Автомашинны сэлбэг, төмрийн хаягдлыг тусгай талбайд цуглуулж байгаа.	0,2
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон	0,3

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын
2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

нөлөөтэй	тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулдаг.	
	Боломжтой хог хаягдлыг дахин ашиглах зарчмаар ажилладаг. Үүний нэг нь хаягдал цаасыг гал түлэхэд ашиглах, принтерийн хорыг дахин цэнэглэж ашиглах, хаягдал төмөр, сэлбэгийг сэлгэн засаж ашиглах гэх мэт	-
Ахуйн аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорхи ус бохирдож болзошгүй	Хэрэглэсэн батерей, принтерийн хор гэх мэт ахуйн аюултай хог хаягдлыг уурхайн талбайд битүүмжлэл сайтай хадгалах	-
	Уурхайгаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах “Хай Би Ойл” үйлдвэрт нийлүүлдэг.	1,3
Ажилчид санаатай болон санамсаргүйгээр ил задгай хог хаях	Уурхайн ажилчдад өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдал, түүнийг хэрхэн ангилан ялгах, боломжтойг дахин ашиглах талаар сургалт явуулдаг.	0,2
Нийт зардал, мян.төг		2,85

9. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэх бөгөөд тайлант 2022 онд ундны усны шинжилгээг 1 удаа, технологийн усны шинжилгээг 1 удаа, хөрс болон агаарын шинжилгээг тус бүр 1 удаа хийлгүүлсэн. Дээрх шинжилгээнүүдийн хариу хэвийн гарсан бөгөөд шинжилгээний үр дүнг хавсралтаар оруулав. Энэ ажилд нийт 0,7 сая төгрөг зарцуулсан.

✓ Авто машины тусгай зориулалтын тэмдэг

Уурхайд ажиллах машин бусад техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засвар хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд гүйцэтгэсэн. Үйл ажиллагааны зардалд тооцогдсон.

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын
2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



ХАНЛАБ ХХК
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба
гудамж 34/6 тоот, Хан Рашаан компанийн байр
Утас: 70109968, 99995316
<http://www.khanlab.mn>



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

ЗАХИАЛГА №: 2022/1332

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: АЙ БИ БИ АЙ ХХК

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ, ТОО: Ус, 4


Д/л	1		2		3		ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 0900:2018/ мг/л
ЛАБ №	Л-14078		Л-14079		Л-14080		
ДЭЭЖ №	Гал тогооны цэвэршүүлсэн ус		Худгийн ус		Баяжуулахын цэвэршүүлсэн нуурын ус		
ЭЛЕМЕНТ / НЭГЖ	мг/л	мг-экв/л	мг/л	мг-экв/л	мг/л	мг-экв/л	мг/л
K ⁺	1.43	0.04	1.43	0.04	1.99	0.05	-
Na ⁺	56.84	2.47	57.84	2.52	52.29	2.27	200
NH ₄ ⁺	<0.10	-	<0.10	-	<0.10	-	6
Ca ²⁺	67.42	3.36	70.68	3.53	47.64	2.38	100
Mg ²⁺	30.55	2.51	26.87	2.21	21.02	1.73	30
НИЙЛБЭР КАТИОН	156.2	8.39	156.8	8.29	122.9	6.43	-
Cl ⁻	85.08	2.40	81.68	2.30	61.26	1.73	350
SO ₄ ²⁻	122.9	2.56	120.9	2.52	90.55	1.89	500
NO ₂ ⁻	<0.05	-	<0.05	-	<0.05	-	1.0
NO ₃ ⁻	1.51	0.02	1.41	0.02	0.85	0.01	50
CO ₃ ²⁻	<1.5	-	<1.5	-	<1.5	-	-
HCO ₃ ⁻	213.6	3.50	222.7	3.65	183.1	3.00	-
НИЙЛБЭР АНИОН	423.1	8.48	426.7	8.49	335.7	6.63	-
НИЙЛБЭР ИОН	579.3		583.5		458.6		-
pH	7.26		7.28		7.38		6.5-8.5
H ₂ SiO ₃	18.65		18.30		13.35		-
ХУУРАЙ ҮЛДЭГДЭЛ (TDS)	498.0		496.0		386.0		1000
ХУУРАЙ ҮЛДЭГДЭЛ (TDS) (тооцоо)	491.2		490.5		380.5		-
ИСЭЛДҮҮЛЭХ ЧАДВАР	5.28		10.72		2.08		-
ХАТУУЛАГ		5.88		5.74			4.11-андартчилал 7.0



Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын
2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ДЭЭЖИЙН ДУГААР: Бөхир усны ивэрлэгдсэн саарал ус
ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-14081

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 4943:2015/	СТАНДАРТ АРГА
1	pH	-	7.56	6-9	MNS ISO 10523:2001
2	Чөлөөт хлор, Cl _{free}	мг/л	<0.10	1.0	
3	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	968	1000	MNS 4423:1997
4	Умбуур бодис, TSS	мг/л	96.00	30	
5	Исэлдэх чадвар /KMnO ₄ /	мгO ₂ /л	36.00	20	
6	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, COD	мгO ₂ /л	460.0	50	MNS ISO 6060:2001
7	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, BOD	мгO ₂ /л	180.9	20	MNS ISO 5815:2001
8	Хүхэрхүстөрөгч, H ₂ S	мг/л	15.34	0.5	MNS 5597:2006
9	Хром, Cr (VI)	мг/л	<0.05	0.01	MNS ISO 11083:2001
10	Хөнгөнцагаан, Al	мг/л	<0.025	0.5	
11	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
12	Бор, B	мг/л	0.35	0.50	
13	Барн, Ba	мг/л	<0.01	1.5	
14	Берилли, Be	мг/л	<0.001	0.001	
15	Кобальт, Co	мг/л	<0.001	0.02	
16	Кадми, Cd	мг/л	<0.005	0.03	
17	Хром, Cr	мг/л	<0.005	0.3	
18	Зэс, Cu	мг/л	<0.02	1.0	
19	Төмөр, Fe	мг/л	0.19	1.0	
20	Марганец, Mn	мг/л	0.11	0.5	MNS (ISO) 11885:2011
21	Молибден, Mo	мг/л	<0.005	0.5	
22	Никель, Ni	мг/л	<0.005	0.2	
23	Фосфор, P	мг/л	9.18	1.5	
24	Хартугалга, Pb	мг/л	<0.01	0.1	
25	Сурьма, Sb	мг/л	0.01	0.05	
26	Селен, Se	мг/л	<0.01	0.02	
27	Стронци, Sr	мг/л	0.78	2.0	
28	Ванади, V	мг/л	<0.01	0.10	
29	Уран, U	мг/л	<0.50	0.05	
30	Цайр, Zn	мг/л	0.05	3.0	
31	Цианид, CN _{tot}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(I):2006
32	Цианид, CN _{free}	мг/л	<0.002	0.050	MNS ISO 6703(II):2006
33	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.005	MNS 4420:1997

Чанарын менежер:  Д. Пүрэвжаргал

Сорилтын үр дүн зөвхөн тухайн дээжинд хамаарна.
Дээжлэлтийн талаарх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2022.07.27
ШИНЖИЛСЭН ОГНОО: 2022.08.15


ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй
ХУУДАСНЫ ТОО: 2

Хамтран ажилласан танд талархлав.

Хуудас 2-2

“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ОНӨААТҮГАЗАР
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИ

213200 Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум
7-р баг, 5-р хэсэг Цагаан эрэг Утас/факс: 7036-3741



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар 2022 он / № 22

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
Дээж авсан газрын нэр

Дээж авсан хүний нэр, албан тушаал
Дээжийн хэмжээ, төрөл
Хүлээн авсан огноо
Дээжийн тодорхойлолт
Шинжилгээ хийсэн аргын стандарт
Шинжилгээ хийж дууссан огноо

“АЙ БИ БИ АЙ” ХХК

Төв аймгийн Заамар сумын Галтын
амны дээд хэсэг

Ашиглалтын инженер Т.Хатанцоож

1.5 литр Хөрсний дээж

2022.10.05

Агрохимийн шинжилгээ

MNS 3310 : 1991

2022.10.10

Үр дүн:

ХӨРСНИЙ АГРОХИМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд (хэмжих нэгж) мг /кг						Ариун цэврийн үнэлгээ
	pH	Сульфат	Нитрат	Фосфор	Аммоний азот	Ялзмаг %	
Карьерийн орчмоос	7,30	53,0	13,42	257,04	144,13	3,90	
Хогийн цэгийн орчмоос	8,00	150,1	15,23	193,71	101,10	0,83	Цэвэр
Стандарт 3297:2019		160	130				

Дүгнэлт:

“АЙ БИ БИ АЙ” ХХК-ны Заамар сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж буй Галтын амны дээд хэсгийн уурхайн дээрхи цэгүүдээс хөрсний дээж авч шинжилгээ хийж MNS 3297 :2019 стандартын дагуу үнэлж үзэхэд цэвэр гэсэн үнэлгээтэй байна.

Шинжилгээ хийсэн: УШНЛ-н химич
Шинжилгээг хянасан УШНЛ-н эрхлэгч




Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Сорилтын дүн зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

“СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС” ОНӨААТҮГАЗАР
УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ЛАБОРАТОРИ

213200 Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум
7-р баг, 5-р хэсэг Цагаан эрэг Утас/факс: 7036-3741



ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

Дугаар 2022 он / № 23

Дээж ирүүлсэн газрын нэр, хаяг, утас
Дээж авсан газрын нэр

Дээж авсан хүний нэр, албан тушаал
Дээжийн хэмжээ, төрөл
Хүлээн авсан огноо
Дээжийн тодорхойлолт
Шинжилгээний аргын стандарт
Шинжилгээ хийж дууссан огноо
Үр дүн:

“АЙ БИ БИ АЙ” ХХК
Төв аймгийн Заамар сумын Галтын
амны дээд хэсэг
Ашиглалтын инженер Т.Хатанцоож
1.5 литр Хөрсний дээж
2022.10.05
Нефтийн бүтээгдэхүүн
MNS 6838 : 2020
2022.10 - 12

ХӨРСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

№	Дээж авсан цэгийн нэр	pH	Нефтийн бүтээгдэхүүн гр/кг	MNS 5850 :2019
1	Уурхайн ШТССтанц	7,90	0,68	2,0

Дүгнэлт:

АЙ БИ БИ АЙ” ХХК-ны Заамар сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж буй
Галтын амны дээд хэсгийн уурхайн дээрхи цэгүүдээс хөрсний дээж авч шинжилгээ
хийж MNS 5850 :2019 стандартын дагуу байна.

Шинжилгээ хийсэн: УШНЛ-н химич
Шинжилгээг хянасан УШНЛ-н эрхлэгч



Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн зөвхөн шинжилсэн дээжинд хүчинтэй

10. Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ

“Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордыг ашиглах төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг тогтоож, технологийн шийдлийг зөв сонгон хэрэгжүүлэхтэй холбоотой зайлшгүй дагаж мөрдөх байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр зэргийг уурхай ашиглах техник-эдийн засгийн үндэслэл дээр үндэслэн холбогдох хууль эрхийн бичиг, норм дүрэм, стандарт, заавар журам зэргийн дагуу ажилласан.

11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтануудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нийт зардал, сая.төг
БО-ны асуудлыг хариуцан ажиллах үүргийг уурхайн ИТА-нуудад үүрэг болгож, хэрэгжилтийг ханган ажилласан.	0,3
Үйл ажиллагаа эхлэхээс өмнө БО-г хамгаалах талаар нийт ажилчдад сургалт зохион байгуулсан.	0,2
БО-ныг хамгаалах талаар хийсэн ажлаа орон нутгийн засаг захиргаанд тайлагнах	0,2
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх гэж тусгасны дагуу Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Заамар сумын гутлын үйлдвэрээс ажлын гутал 122.02 сая төгрөгөөр авсан.	122.02
Нийт, сая.төг	122,72

12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүллийн ажлыг 2022 оны 4-р сарын 10-ны өдөр Хайлааст багийн ИНХ дээр хийсэн.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжилтийн зардал

№	Арга хэмжээ	Зардал, сая.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ	8,9
2	Нөхөн сэргээлт	1,0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	63,6
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	49
5	Түүх,соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	0
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,8
7	Хог,хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,85
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	122,72
9	Орчны хяналт шинжилгээ	0,7
10	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах	1,0
	Нийт зардал, мян.төг	252,57

Тус уурхай нь 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтэд нийтдээ 252,57 сая төгрөгийг 11-р сарын 30-ны байдлаар зарцуулаад байна.

Дүгнэлт

2022 онд “Төв аймгийн Заамар сумын нутагт орших Галтын амны дээд хэсгийн” алтны шороон орд нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-ийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг хийх, мөн анги тосгоны эрүүл ахуйг сайжруулах, сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба ил уурхайн тоосжилт хөрсний эвдрэлийг бууруулах зэрэг олон ажлыг хийж гүйцэтгэсэн.

Үүнд:

Уул уурхайн үйл ажиллагааны үр дүнд эвдрэлд орсон газруудыг хуучин төрхөнд нь дөхүүлэх үүднээс баталсан стандартын дагуу техникийн нөхөн сэргээлтийг явуулан, сөрөг нөлөөлөлийг багасгах урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Уурхайн олборлолтын явцад хөрс хуулалтын ажлыг уулын ажилтай уялдуулж тээвэртэй системээр дотоод овоолгоор ашиглагдсан орон зай руу хийж нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж байсан.

Нийт 3.0 га талбайд техник, биологийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд орчны бүст 300 ширхэг мод тарьсан, байгаль орчны төлөвлөгөөний биелэлтийн зардлын дүн 252,57 сая төгрөг байгаа бөгөөд зардал нь үйлдвэрлэлийн зардлын түлш шатхуун, цалин хөлс, түрээс гэх мэт зардлаар тооцогдон гүйцэтгэгдсэн болно.



ТУУЛ ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1, 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, “Усны газар”-ын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/808 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 161 “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-020602 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Доргонт, Улаан ухаа”-ны алтны шороон ордоос 79'770.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэгцээнд шаардагдах 115'581.5 м³ усыг Туул голоос, унд-ахуйн хэрэглээний 6'196.5 м³ усыг өөрийн эзэмшлийн гүний худгаас 2022 онд ашиглахыг “Ай Би Би Ай” ХХК-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Ус ашиглагчтай гэрээ байгуулах, ашиглах боломжит усны нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах алба /Б.Оюунболд/, Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах алба /П.Энхбаяр/, нарт үүрэг болгосугай.

Гурав. Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 30 дугаар зүйлийн дагуу ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагыг ханган ажиллах, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор Сав газрын захиргаанд ирүүлэхийг “Ай Би Би Ай” ХХК /Ч.Оюунгэрэл/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.НЯМДОРЖ

БАТЛАВ
ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН
ГҮЙЦЭТГЭГЧ
363364 Д.НЯМДОРЖ
УЖА0053
2022 оны 07 дугаар сарын ...

БАТЛАВ
“АЙ БИ БИ АЙ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ
Ч.ОЮУНГЭРЭЛ
2022 оны 07 дугаар сарын 08

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар УНТ 22/42

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, “Усны газар”-ын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/808 дугаартай албан бичгээр ирүүлсэн Дугаар 161 “Ус ашиглуулах дүгнэлт”, Туул голын сав газрын захиргааны даргын 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/57 дугаар тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн П.Энхбаяр, Ус ашиглагчийг төлөөлж тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Ажилчны гудамж, Улсын бүртгэлийн 9011453143 гэрчилгээ, 5809797 регистрийн дугаартай “Ай Би Би Ай” ХХК-ийн ашиглалтын инженер Т.Хатанцзож нар ус ашиглах талаар харилцан тохиролцож энэхүү гэрээг 2022 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 *Ус ашиглах зориулалт:* Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-020602 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Доргонт, Улаан ухаа алтны шороон орд”-ын үйлдвэрлэл технологийн хэрэгцээнд Туул голоос ус ашиглана.

2.1.1. Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4.4-т заасны дагуу 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөөлөл оролцуулж, дүгнэх хуудсыг баталгаажуулна.

2.2. *Нийт ашиглах усны хэмжээ:* 79'770.0 м³ элс угаах үйлдвэрлэл, технологийн болон бусад хэрэглээнд зарцуулах ус 115'581.5 м³/жил;

2.2.1. Унд ахуйд ашиглах ус: 6'196.5 м³/жил;

2.2.2. Ашигт малтмал олборлох, баяжуулахад ашиглах гадаргын ус: 107'360.0 м³;

2.2.4. Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах гадаргын ус: 8'100.0 м³/жил;

2.2.5. Мод тарихад зарцуулах ус: 121.5 м³/жил.

2.3. *Усны чанар, найрлага:* 2022 оны 06, 09, 11 дүгээр сард хаягдлын нуурын уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг ус ашиглалтын тайланд хавсаргаж Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. *Усны эх үүсвэр:*

2.4.1. *Байршил:* Технологийн болон бусад хэрэглээний усыг Туул голоос, унд ахуйн усыг гүний 1 худаас авч ашиглана. ахуйн худгийн байршил: 48° 08'01.22", 104° 19'03.22".

2.4.2. *Барилга байгууламж:* Тунгаах нуур 45'000.0 м³, цэвэр усан сан 30'000.0 мян.м³ эзлэхүүнтэй. Туул голоос AP 2.5-R72 маркийн дизел хөдөлгүүртэй 72 м³/цаг хүчин чадалтай насосоор эргэлтийн усан санд ус өгнө. Эргэлтийн усан санд 360 м урттай 100 мм голчтой полимер хоолойгоор, эргэлтийн сангаас угаах төхөөрөмж рүү НДВ маркийн насосоор ус татна.

2.4.3. *Тоног төхөөрөмжийн нэр, марк:* CATERPILLAR маркийн экскаватор 4 ш, CATERPILLAR CAT D8R маркийн бульдозер 1 ш, CATERPILLAR CAT 980H маркийн утгуурт ачигч 2 ш, CATERPILLAR 773E маркийн автосамосвал 5 ш, FM440 маркийн автосамосвал 9 ш, нортбенз 2529K маркийн автосамосвал 4 ш, Баяжуулах үйлдвэрт ТӨ-100 маркийн хүрдэт шигшүүр 1 ш, ТӨ-100 маркийн хоригт цорго 1 ш, 1Д-500-63 маркийн насос 1 ш, тус тус ашиглана.

2.4.4. *Насосны хүчин чадал:* Элсийг 100 м³/цаг чадалтай ТӨ-100 маркийн скрубберээр угаан баяжуулна.

2.5. *Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага:* Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартын шаардлагыг мөрдлөг болгоно. Стандартаас давсан агууламжтай хаягдал усыг байгальд нийлүүлж буй тохиолдолд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу төлбөр тооцно.

2.6. *Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:*

2.6.1. Технологийн хаягдал усыг тунгаах нууранд тунгааж, эргүүлэн ашиглана. Стандартаас давсан агууламжтай хаягдал усанд Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар батлагдсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам” -ын дагуу төлбөр тооцно;

2.6.2. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг Байгаль орчин, аялал жуулчлалын Сайд, Эрүүл мэндийн Сайдын 2018 оны А/82/128 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”-ын дагуу тохижуулж ашиглана.

2.7. *Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:*

2.7.1. Туул голоос ус татах насосыг байрлуулахдаа голын эрэг, голдирлыг хөндөхгүйгээр байрлуулна.

2.7.2. Усны эх үүсвэрийг хамгаалах усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлж жил бүр түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төсөвт суулган орон нутгийн захиргаа, байгаль хамгаалагчаас санал авч сэргээн засварлах шаардлагатай булаг шандыг тохижуулах.

2.7.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

2.7.4. Биологийн нөхөн сэргээлийн ажлыг хийхгүй.

2.8. *Усны тоолуур:* Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг хэрэгжүүлж ажиллана. Унд ахуйн худагт тоолуур суурилуулж тоолуурын заалтын тэмдэглэлийг тогтмол хөтөлж, баталгаажуулна.

2.9. *Ус ашигласны төлбөрийн хэмжээ:*

2.9.1. Ашигт малтмал олборлон, баяжуулахад ашиглах 107'360.0 м³ гадаргын усны төлбөр **25'615'022.0** /Хорин таван сая зургаан зуун арван таван мянга хорин хоёр/ төгрөг, зам талбайн тоосжилт дарахад ашиглах 8'100.0 м³ гадаргын усны төлбөрт **644'193.0** /Зургаан зуун дөчин дөрвөн мянга нэг зуун ерэн гурван/ төгрөг, Ногоон байгууламж мод усалгаанд 121.5 м³ гадаргын усны төлбөрт 2'255.0 /Хоёр мянга хоёр зуун тавин тавн мянга/ төгрөг, нийт **26'261'470.0** /Хорин зургаан сая хоёр зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун далан/ төгрөгийг Төв аймгийн Татварын хэлтсийн дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 60 хувийг гуравдугаар улиралд, 40 хувийг дөрөвдүгээр төлнө.

2.9.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

3

2.9.3. Гэрээнд зааснаас хэтрүүлэн ашигласан усанд Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-д заасны дагуу төлбөр тооцно.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.6, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.9, 29 дүгээр зүйлийн 29.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33 дугаар зүйлийн дагуу хариуцлага хүлээнэ.

3.3. Ус ашиглуулах дүгнэлтээр тавьсан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийн хангаж ажиллана.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд жил бүрийн ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээг тухайн оны эхний улиралд багтаан байгуулна.

4.3. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ.

4.4. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцлийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд гэрээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.5. Тайлант оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Туул голын сав газрын захиргаанд ирүүлдэг ус ашиглалтын тайланг үндэслэн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг 2 хувь үйлдэн баталгаажуулах бөгөөд гэрээнд заасан төлбөрийг барагдуулаагүй тохиолдолд дараа оны гэрээ хийгдэхгүй.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ: УС АШИГЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Мэдээлэл, хяналт шалгалтыг зохицуулах
албаны дарга


/Б.ОЮУНБОЛД/

Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалт
хариуцсан ахлах мэргэжилтэн

 /П.ЭНХБАЯР/

Туул голын сав газрын захиргааны
байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө
Харилцах утас: 70003716, 70003714,
70002592


“Ай Би Би Ай” ХХК-ийн ашиглалтын
инженер



/Т.ХАТАНЦООЖ/

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
20-р хороо, Ажилчны гудамж.

Харилцах утас: 99113446, 99140674
И-мэйл: ibbillc55@gmail.com



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2022 оны 07 дугаар
сарын 07-ний өдөр

Дугаар-161

Улаанбаатар
хот

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар:

“Ай Би Би Ай” ХХК-ийн захирал Ч.Оюунгэрэл, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Ажилчны гудамж, утас: 99113446, факс: (976) 70177447. Улсын бүртгэлийн дугаар: 9011453143, регистрийн дугаар: 5809797.

2. Төслийн нэр, байршил:

“Ай Би Би Ай” ХХК-ийн Доргонот, Улаан ухаа алтны шороон орд нь Төв аймгийн Заамар сумын төвөөс 35 км, Улаанбаатар хотоос 195 км зайд байрладаг. Туул голын сав газарт хамаарагдана.

3. Төсөл хэрэгжүүлэгч:

“Ай Би Би Ай” ХХК.

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат: /X,Y/

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020602. Талбайн хэмжээ: 3,506.94га.

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	104°22'59.42"	48°10'49.82"	16	104°18'14.07"	48°9'20.5"
2	104°23'27.69"	48°10'28.59"	17	104°18'19.91"	48°9'20.5"
3	104°25'40.4"	48°10'38.49"	18	104°18'19.91"	48°9'21.76"
4	104°25'34.32"	48°8'5.31"	19	104°18'22.95"	48°9'21.76"
5	104°18'47.94"	48°8'2.81"	20	104°18'22.95"	48°9'23.63"
6	104°18'47.94"	48°8'14.35"	21	104°18'25.33"	48°9'23.63"
7	104°18'42.36"	48°8'14.35"	22	104°18'25.33"	48°9'25.88"
8	104°18'42.36"	48°8'17.79"	23	104°18'27.74"	48°9'25.88"
9	104°18'33.01"	48°8'17.79"	24	104°18'27.74"	48°9'49.82"
10	104°18'33.01"	48°8'20.26"	25	104°18'34.91"	48°9'49.82"
11	104°18'25.15"	48°8'20.26"	26	104°18'34.91"	48°9'21.82"
12	104°18'25.15"	48°8'48.82"	27	104°20'0.92"	48°9'21.82"
13	104°18'18.69"	48°8'48.82"	28	104°20'0.92"	48°9'49.82"
14	104°18'18.69"	48°9'3.15"	29	104°21'40.91"	48°9'49.82"
15	104°18'14.07"	48°9'3.15"	30	104°21'40.91"	48°10'49.82"

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт :

Алтны шороон ордыг ил аргаар олборлон, баяжуулна.

6. Үйлдвэрийн техник, технологи: /ажиллах горим, хүчин чадал/

Уурхайн олборлолтод ажиллуулах техник:

CATERPILLAR маркийн эксковатор 4 ш	KOMATSU PC1250SP8 маркийн эксковатор 1 ш
CATERPILLAR CAT D8R маркийн бульдозер 1 ш	KOMATSU D65EX маркийн бульдозер 1 ш
CATERPILLAR CAT 980H маркийн утгуурт ачигч 2 ш	VOLVO FM440 маркийн автосамосвал 9ш
CATERPILLAR 773E маркийн автосамосвал 5 ш	NORTHBENZ 2529K маркийн автосамосвал 4 ш


Баяжуулах боловсруулах үйлдвэрт ажиллуулах тоног төхөөрөмж:

ТӨ-100 маркийн хүрдэт шигшүүр 1ш	1Д-500-63 маркийн насос 1ш
ТӨ-100 маркийн хоригт цорго 1ш	

Элсийг 100м³/цаг хүчин чадалтай ТӨ-100 маркийн скрубберээр угаан баяжуулна. 2022 онд 162 хүн 2 ээлж, 11 цагаар 255 хоног ажиллахаар төлөвлөсөн.

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:

2022 онд 2,099,5700.0 м³ хөрс хуулж, 79,770.0 м³ элс олборлож 75.63 кг алт гарган авна. Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд 300 ш мод тарина. Биологийн нөхөн сэргээлт хийхгүй.



8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ:/шоо.метрээр/
Унд ахуйн усны хэрэгцээг 1.6 л/сек ундаргатай гүний худгаас, технологийн хэрэгцээний усыг Туул голоос тус тус хангана. Унд ахуйд хоногт 17.25 м³ ус ашиглана. Технологийн усны 80 хувийг эргэлтээр 20 хувийг нөхөн сэлбэлтээр авч ашиглана.

9. Усны барилга байгууламжууд: /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/
Цэвэр усан сан 30,000.0 м³, тунгаах сан 45,000.0 м³, бохир усан сан 75,000.0 м³. Туул голоос AP 2.5-R72 маркийн дизель хөдөлгүүртэй 72 м³/цаг хүчин чадалтай насосоор эргэлтийн усан санд ус өгнө. Эргэлтийн усан сангаас баяжуулах төхөөрөмжид НДВ маркийн насосоор ус өгнө.

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур: /насосны хүчин чадал, марк/
Худгийн байршил:

№	Уртраг	Өргөрөг	Ундарга (л/с)	Насосны марк	Тоолуурын	
					Марк	Дугаар
1	104°19'3.22"	48°08'1.22"	1.6	QJD	Тоолуургүй	

11. Дамжуулах байгууламж: /шугам сүлжээний урт, диаметр/
Туул голоос ус татах уян хоолойн урт 320.0 м, голч 150 мм. Туул голоос AP 2.5-R72 маркийн дизель хөдөлгүүртэй 72 м³/цаг хүчин чадалтай насосоор эргэлтийн усан санд ус өгнө. Эргэлтийн усан сангаас баяжуулах төхөөрөмжид НДВ маркийн насосоор ус өгнө.

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:
Ахуйн бохир усыг биологийн аргаар задалж хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл:
Туул голын баруун дэнжийн галтын хэсэг, Галтын амны дээд хэсгийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн нэмэлт тодотголыг 2022 онд “САБЛАЙМ” ХХК хийж гүйцэтгэсэн байна.

14. Онцгой нөхцөл:
Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах;

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм стандартын дагуу усны зарцуулалтыг тооцох:
Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны хэрэглээний норм”-ын дагуу тооцоход үйлдвэрлэлийн хэрэгцээнд:

$$79,770.0 \text{ м}^3 \times 4.0 \text{ м}^3 = 319,080.0 \text{ м}^3 \text{ ус шаардагдана.}$$

Техникийн хүчин чадлаар тооцоход:
100 м³/цаг хүчин чадалтай 1 ш – скруббер.

100 м ³ /цаг х 22 цаг = 2,200 м ³ /хон	- хоногт угаах элсний хэмжээ
2,200 м ³ /хон х 4.0 м ³ = 8,800.0 м ³ /хон	- хоногт шаардагдах усны хэмжээ
8,800.0 м ³ /хон х 5 хон = 44,000.0 м ³	- эргэлтийн усан санд тогтмол байлгах усны хэмжээ
79,770.0 м ³ : 2,200 м ³ /хон = 36 хон	- элс угаан баяжуулахад зарцуулах хугацаа
8,800 м ³ /хон х 0.2 х 36 хон = 63,360.0 м ³	- ууршилт, шүүрэлтээр алдагдах усны хэмжээ
44,000 м ³ + 63,360.0 м ³ = 107,360.0 м ³	- баяжуулалтад ашиглах нийт усны хэмжээ
45,000 м ² х 2 л/м ² х 90 хон = 8,100.0 м ³	- зам, талбайн тоосжилт дарахад ашиглах ус (БОНУНТ-ийн 41х)
300 ш мод х 45 л/ш х 9 удаа = 121.5 м ³	- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихад ашиглах ус
107,360.0 + 8,100.0 + 121.5 = 115,581.5 м ³	- жилд ашиглах нийт усны хэмжээ

162 хүн х 150 л/хон х 255 хон = 6,196.5 м³	- унд, ахуйн усны жилийн хэрэгцээ
--	-----------------------------------

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу унд, ахуйн зориулалтаар ашиглах **6,196.5 м³** усыг төлбөрөөс чөлөөлнө.
Ашигт малтмал олборлон, баяжуулахад **107,360.0 м³**, зам, талбайн тоосжилт дарахад ашиглах **8,100.0 м³**, мод тарихад ашиглах **121.5 м³** гадаргын усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 дугаар тогтоолоор баталсан усны экологи, эдийн засгийн суурь үнэлгээ, ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тус тус үндэслэн урьдчилсан байдлаар тооцвол:

Ашигт малтмал олборлох, баяжуулахад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:
1 м³ гадаргын усны үнэ: 2651 төг/м³ х 0.1 х 0.9 = 238.59 төг
2651 төг/м³: Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
10%: Засгийн газрын 326-р тогтоолын 7а-д гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
0.9: Ашигт малтмал баяжуулахад гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр;
107,360.0 м³ х 238.59 төг = 25,615,022.0 төг

Зам, талбайн тоосжилт дарахад гадаргын усны нөөц ашигласны төлбөр:
1 м³ гадаргын усны үнэ: 2651 төг/м³ х 0.1 х 0.3 = 79.53 төг
2651 төг/м³: Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
10%: Засгийн газрын 326-р тогтоолын 4-т замын зориулалтаар гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
0.3: Авто замын зориулалтаар гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр;
8,100.0 м³ х 79.53 төг = 644,193.0 төг

Мод усалгаанд гадаргын усны нөөц ашигласны төлбөр:
1 м³ гадаргын усны үнэ: 2651 төг/м³ х 0.01 х 0.7 = 18.56 төг/м³
2651 төг/м³: Засгийн газрын 302-р тогтоолоор Туул голын сав газарт тогтоосон гадаргын усны экологи-эдийн засгийн суурь үнэ;
1%: Засгийн газрын 326-р тогтоолын 9-т заасан газар тариалангийн үйлдвэрлэлийн зориулалтаар гадаргын ус ашигласныг тооцох төлбөрийн хувь, хэмжээ;
0.7: Ногоон байгууламжийн усалгаанд гадаргын ус ашигласныг тооцох итгэлцүүр;
121.5 м³ х 18.56 төг = 2,255.0 төг

Нийт төлбөр: 25,615,022.0 төг + 644,193.0 төг + 2,255.0 төг = 26,261,470.0 төг
(Хорин зургаан сая хоёр жаран нэгэн мянга дөрвөн зуун далан төгрөг).

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар:
Нөхөн сэлбэлтээр авах усны хэмжээг 20 хувиас хэтрүүлэхгүй байх;

18. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө:

- Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Туул голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулж ажиллах;
- Усны тухай хуулийн 30.1.4-т заасны дагуу ундны усны эх үүсвэрийн гүний худаг, эргэлтийн болон Туул голоос ус татдаг шугамыг тоолууржуулан баталгаажуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 26.3.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;
- Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;
- Туул голоос ус ашиглахдаа Усны тухай хуулийн 30.6-д заасны дагуу голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор усыг дамжуулан авч ашиглах;
- Хаягдал усны дүгнэлтийг тухайн жилийн эхний улиралд багтаан гаргуулах;
- Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;

- Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;
- Үйл ажиллагаа нь зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;
- Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ)-г 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим хаягаар болон холбогдох газруудад хүргүүлж ажиллах.

УС АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДАРХАНЧИМЭГ

УС АШИГЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Х.МЯГМАРЖАВ

Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Галтын амны дээд хэсэг”-ийн алтны шороон ордын
2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Салбар /Branch		Он /Year	Сар /Month	Өдөр /Day	Мөнгөний нэгж /Currency
3096		2022	11	16	MNT
ШИЛЖҮҮЛЭГЧ Sender	Нэр /Name АЙ БИ БИ АЙ	Мөнгөн дүн тоогоор /Amount in figures 26261470			
	Дансны дугаар /Account No. 3096002086 MN210030003096002086	Мөнгөн дүн бичгээр /Amount in letters Хорин зургаан сая хоёр зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун далан төгрөг			
ХҮЛЭЭН АВАГЧ: Beneficiary	Хүлээн авагчийн нэр /Name 010001МОСТМОНИ БЭЛЭН ГҮЙЛГЭЭНИЙ ТҮР ДАНС /MNT/	Төлбөрийн зориулалт /Details of payment ММ:Ус ашигласны төлбөр АЙ БИ БИ АЙ			
	Хүлээн авагчийн банк /Beneficiary's bank				
	Дансны дугаар /Account No. 3096002599				
Гарын үсэг /Signature	Тамга /Stamp				
1					
2					
ТЭМДЭГЛЭЛ /Note			Гүйлгээний шимтгэл /Transaction fee	Гүйлгээний дугаар /Transaction code	
Дансны дугаар /Account number	Гүйлгээний дүн /Transaction amount	Утасны дугаар /Phone number		83559000255435	
3096002086	(26 261 470)	95111111	Теллер:	УЧРАГ.ГК	
			Хянасан:		
Ус ашигласны төлбөр			*Би энэхүү баримт бичгэдсэн мэдээллийн үнэн зөв болохыг баталж гарын үсгээ зурал. I hereby certify that all information provided on this form is true and correct.		

БАТЛАВ: 

АЙ БИ БИ АЙ ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ч.ОЮУНГЭРЭЛ

БАТЛАВ: 

МОНПИТИ-ОЙЛ ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.НАРАНХҮҮ

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ АЖ
АХУЙН НЭГЖИД ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ ГЭРЭЭ**

2022 оны 2...-р сарын 11... өдөр

№2022/02/04

Орхон аймаг

Энэхүү гэрээг нэг талаас 5809797 регистрын дугаартай “Ай би би ай” ХХК, /цаашид “Шилжүүлэгч” гэх/, түүнийг төлөөлж Ашиглалтын инженер албан тушаалтай Тунгалаг овогтой Хатанцоож, нөгөө талаас Орхон аймаг, Баян-Өндөр сум, Малчин баг, Нарийн хөндий 3 замын уулзвар өөрийн үйлдвэрийн байр хаягт байрлалтай 4388054 регистрын дугаартай “Монпители ойл” ХХК, /цаашид “Шилжүүлэн авагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Баасансүрэн овогтой Наранхүү нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2 –р хавсралтаар батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам” - ыг үндэслэл болгон доорх нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

1. ҮНДСЭН НӨХЦӨЛ

- 1.1 Уул уурхайн хүнд машин механизмын үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, багасгах, ангилан ялгах, дахин ашиглах, боловсруулах, устгах хог хаягдлын менежментийн шатлалыг бий болгох. Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэхэд оршино.
- 1.2 Энэхүү гэрээний зорилго нь Шилжүүлэгч тал нь гэрээний хавсралт №1-д заасан эрх бүхий байгууллагаас батлагдсан дагалдах бичгийн маягт /цаашид “дагалдах бичиг” гэх/-д заасан бүх төрлийн ашиглалтаас гарсан тос масло, хаягдал дугуй зэрэг аюултай хог хаягдлыг нэр төрөл, тоо хэмжээний дагуу Шилжүүлэн авагчид шилжүүлэх, шилжүүлэн авагч нь холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын дагуу аюултай хог хаягдлыг шийдвэрлэх харилцааг зохицуулна.
- 1.3 Энэхүү гэрээний үйлчилгээний хөлсийг Талууд дараах байдлаар тохиролцов. Үүнд:

№	Төрөл	Хаягдлын хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн хөлс /төг/	Нийт /мян.төг/
1	Ажилласан тос, масло, хаягдал гидрийн шингэн, антифризийн шингэн болон бусад төрлийн хаягдал тос.	40	тн/жил	0 л/төг	0

- 1.4 Шилжүүлэн авагч нь үйлчилгээний хөлсийг аюултай хог хаягдлыг хүлээн авч тээвэрлэсэн тухай бүр Гэрээний 3.1-т заасан актыг үндэслэн тооцож, Шилжүүлэгчээс нэхэмжилнэ.
- 1.5 Шилжүүлэгч нь Гэрээний 1.4-т заасан төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш хуанлийн 15 хоногийн дотор үйлчилгээний хөлсийг төлөх үүрэгтэй.
- 1.6 Гэрээний хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.7 Энэхүү гэрээний хавсралт №1-д заасан дагалдах бичгийг Шилжүүлэгчээс Шилжүүлэн авагчид аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгөх бүрт үйлдэж, гэрээнд хавсаргана.

- 1.8 Шилжүүлэн авагч нь энэхүү гэрээний 3.1-г заасан байршлаас аюултай хог хаягдлыг авч тээвэрлэх ба Шилжүүлэгч нь үйлчилгээ авах талаар Шилжүүлэн авагч талд ажлын 3-5 хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

2. БАТАЛГАА

- 2.1 Шилжүүлэн авагч нь “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх” чиглэлээр Монгол улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын яамнаас №0000016 дугаарын тусгай зөвшөөрөлтэй /цаашид “зөвшөөрөл бүхий” гэх/ аж ахуйн нэгж байгууллага мөн болно. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг энэхүү гэрээнд хавсаргана.
- 2.2 Шилжүүлэн авагч нь Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын хавсралтаар батлагдсан “аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-д заасан шаардлагыг бүрэн хангасан байна.
- 2.3 Шилжүүлэн авагч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэхдээ энэхүү гэрээний 2.1 дүгээр зүйлд заасан зөвшөөрөлгүй этгээдэд дамжуулан худалдах, байгаль экологид хортой аргаар ашиглах, устгах, ил задгай хаяхыг хатуу хориглоно.
- 2.4 Шилжүүлэн авагч нь дагалдах бичиггүй аюултай хог хаягдлыг хүлээн авахыг хатуу хориглоно.

3. ШИЛЖҮҮЛЭХ НӨХЦӨЛ, ХУГАЦАА

- 3.1 Шилжүүлэгч нь Шилжүүлэн авагчид “Ажилласан тос” аюултай хог хаягдлыг тээвэрлүүлэхээр шилжүүлэн өгөх бөгөөд Шилжүүлэн авагч нь аюултай хог хаягдлыг ачихдаа Шилжүүлэн авагчийн төлөөллийг байлцуулж, хүлээн авсан аюултай хог хаягдлын төрөл, хэмжээ нэгжийг заасан 2 хувь акт үйлдэнэ.
- 3.2 Талууд энэхүү гэрээний 3.1-д заасан хүлээлгэн өгөх цэгт аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгч, акт үйлдсэнээр Шилжүүлэн авагч нь аюултай хог хаягдлыг хүлээн авсанд тооцно.
- 3.3 Энэхүү гэрээ нь 2022 оны 04-р сарын 11-ны өдрөөс 2022 оны 12-р сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд хүчин төгөлдөр байна.

4. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1 **Шилжүүлэгчийн эрх, үүрэг**
- 4.1.1 Дагалдах бичигт заасан нэр төрөл, тоо хэмжээний аюултай хог хаягдлыг заасан хугацаанд хүлээн авахыг Шилжүүлэн авагчаас шаардах;
- 4.1.2 Шилжүүлэн авагчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр шаардах;
- 4.1.3 Дагалдах бичигт заасан нэр төрөл, тоо хэмжээтэй аюултай хог хаягдлыг заасан хугацаанд Шилжүүлэн авагчид хүлээлгэн өгөх.
- 4.1.4 Хуульд заасан бусад эрх, үүрэг.
- 4.2 **Шилжүүлэн авагчийн эрх, үүрэг**
- 4.2.1 Шилжүүлэгчээс гэрээнд заасан нөхцөлийн дагуу аюултай хог хаягдлыг шилжүүлэн өгөхийг шаардах;
- 4.2.2 Аюултай хог хаягдлыг зориулалтын бусаар буюу хүн болон байгаль орчинд хор хөнөөл учруулах байдлаар /хүнсний, ахуйн/ ашиглахгүй байх;
- 4.2.3 Зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага мөн болохыг нотолсон баримтыг Шилжүүлэгч талд гаргаж өгөх, гэрээнд хавсаргах;
- 4.2.4 Энэхүү гэрээний дагуу гүйцэтгэх үйл ажиллагаанаас үүдэлтэй аливаа эрсдлийг бүрэн хариуцах;
- 4.2.5 Шилжүүлэгч тал энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчин аюултай хог хаягдлыг зүй бусаар зарцуулсан тохиолдолд холбогдох Байгаль орчны газар болон Мэргэжилийн хяналтын газар, харьяа экологийн цагдаагийн газарт мэдэгдэл хүргүүлэн энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.
- 4.2.6 Хуульд заасан бусад эрх, үүрэг.

5. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Аюултай хог хаягдал, түүнээс үүсэх эрсдлийг Шилжүүлэгч тал гэрээний 3.1-д заасан хүргэлтийн цэгт хүргэх хүртэл, хог хаягдлыг хүргэлтийн цэгээс хүлээж авснаас хойших эрсдлийг Шилжүүлэн авагч тал тус тус хүлээнэ.
- 5.2 Шилжүүлэн авагч тал аюултай хог хаягдлыг зориулалтын бусаар ашигласнаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлсэн аливаа сөрөг нөлөө, хохирлыг бүрэн хариуцна.
- 5.3 Шилжүүлэн авагч тал аюултай хог хаягдлыг гуравдагч этгээдэд шилжүүлснээс үүсэх аливаа сөрөг нөлөө, гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг дангаараа бүрэн хариуцна.
- 5.4 Шилжүүлэн авагч талд аюултай хог хаягдлын хүлээн авснаар Монгол Улсын хог хаягдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан хог хаягдлыг өмчлөх эрх шилжинэ.

6. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Энэхүү гэрээтэй холбоотой бүхий л маргаан, зөрчилдөөнийг талууд харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.
- 6.2 Хэрэв талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.3 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.


7. БУСАД


- 7.1 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэх бөгөөд нэг хувийг Шилжүүлэн авагч тал, хоёр хувийг Шилжүүлэгч тал тус тус хадгална.
- 7.2 Энэхүү гэрээ нь Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 7.3 Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр үйлдэх бөгөөд талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

ТАЛУУДЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Монпити Ойл” ХХК-ийн

“Ай би би ай” ХХК-ийн


Б.Наранхүү
Захирал


Т.Хатанцоож
Ашиглалтын инженер

99054755
96664755

